

“ХАМБА НОМУН ХАНЫ БУМАН ЗАРЛИГААС ХОРИН ТАВТЫН АЙМАГ ОРШВОЙ” ЗОХИОЛ ДАХЬ ГАВАР-25 НАЙРЛАГЫН СУДАЛГАА

Базаррагчаа Мягмардаш¹, Гангаа Болорцэцэг¹, Лхагва-Очир Анхцацрал², Түмэнбат
Цэцэгдарь¹, Шарав Болд^{1*}

Уламжлалт Анагаах Ухааны Тэнхим

¹Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль

²“Ач” Анагаах Ухааны Их Сургууль

*Цахим хаяг: shrvbold@gmail.com

A STUDY ON THE COMPOSITION OF THE “GABUR-25” IN THE FRAMEWORK OF “MKHAN CHEN CHOS KYI RGYAL PO’I GSUNG ‘BUM LAS NYER LNGA’I SDE TSHAN”

Myagmardash Bazarragchaa¹, Bolortsetseg Gangaa¹, Ankhtsatsral Lkhagva-Ochir², Tsetsegdari
Tumenbat¹, Bold Sharav^{1*}

Department of Traditional Medicine

¹Mongolian University of Pharmaceutical Sciences

²“Ach” Medical University

*Email: shrvbold@gmail.com

Abstract

Introduction: Researchers Herbert Schwabl and Cecile Vennos highlight Tibetan medicine’s significance, noting that Gabur-25 was registered in Switzerland as Padma-28 in 1977. This formula is used internationally for improving blood circulation and treating heart pain, limb numbness, skin discoloration, ulcers, chronic inflammation, tinnitus, and dizziness. The primary ingredient in Padma-28 is Gabur-25.

The framework “Mkhan Chen Chos Kyi Rgyal Po’i Gsung ‘Bum Las Nyer Lnga’i Sde Tshan,” written by Mongolian healer Lama Gegeen Luvsandanzanjantsan (1639–1704), compiles 30 medicinal formulas, each containing 25 ingredients, including Gabur-25. This study examines its composition, quality, and efficacy.

Results

A comparative analysis of Gabur-25 from Luvsandanzanjantsan’s work with compositions from “The Four Tantras of Medicine,” “Abstract of Nandin Erdene Extract,” and “The Four Mineral Waters” revealed 17 shared ingredients and 8 variations. These differences suggest adaptations for treating excessive heat-related conditions, gout, and cerebral palsy disorders.

Conclusion

Gabur-25 in Luvsandanzanjantsan’s work differs from other sources by seven medicinal ingredients. It is particularly effective for dispersing excess heat, treating gout-related disorders, and aiding paralysis-influenced conditions. This distinction highlights Gabur-25 as a modified formulation tailored to regional ailments based on the author’s experience. The study underscores the evolving nature of traditional Tibetan medicine and its adaptation to specific health conditions.

Key words: Gabur-25, Medicinal Raw Materials, Lama Gegeen Luvsandanzanjantsan

Үндэслэл

Нүүдэлчдийн уламжлалт соёлын их өв сангийн нэгэн чухал хэсэг бол тэдний саруул аж төрөх соёл, түүний нэгэн чухал хэсэг болох уламжлалт анагаах ухааны мэдлэг мөн¹. Монголын уламжлалт анагаах ухаан бол Монголчуудын өвөг дээдсийн өвчин эмгэгтэй урт хугацааны турш тэмцэж ирсэн, туршлага суусан, алдаа оноогоо дүгнэсэн,

бусад улс үндэстний анагаах ухааны онол, практикийг нэгтгэн дүгнэж 5000 жилийг туулж ирсэн анагаан эдгэрүүлэх, өвчнөөс сэргийлэх мэдлэгийн цогц сан² бөгөөд энэ их мэдлэгийг гүнзгийрүүлэн судлах ажил одоо цагт чухал байна. Тиймээс уламжлалт анагаах ухааны эртний сурвалж бичгүүдийг орчуулан, агуулгыг судлах, эм судлал, эм найрлага судлалын ажил эрчимжиж байна.

Уламжлалт анагаах ухааны эм найрлагыг 3 үндсэн аргаар найруулах бөгөөд үүнд амтны найрлага, шингээлтийн найрлага, чадлын найрлага байна. Эм нь амт, чадал, шингээлт гурвуулаа хэвийн зохилдсон байвал тохирсон өвчинд хүчтэй үйлчлэх³ бөгөөд эм найрлага дотор нь гол эм, хавсрагч эм, туслагч эм, тохируулагч эм зэрэг дөрвөн хэсгээс бүрэлддэг. Мөн хүч ихтэй, хүнд өвчнийг анагаах их найрлагатай эмд голлогч эм 2 зүйл, хавсрагч эм 2 зүйл, туслах эм 5 зүйл, тохируулагч 9 зүйлийг хийж найруулна⁴ гэсэн байна. Эндээс үзвэл олон найрлагатай эм нь хүч ихтэй өвчинд өгөх бөгөөд хоруу чанар багатай, өргөн хүрээний үйлдэлтэй байна.

Судлаач Херберт Швабл, Сециле Веннос нарын “Анагаах ухааны уламжлалаас уламжлалт анагаах ухаан руу: Европын хүрээн дэх Төвөдийн томьёолол” судалгаанд “Төвөдийн анагаах ухаан нь анагаах ухааны чухал аргуудын нэг юм. 20-р зуунд Төвөдийн жор Швейцарьт ирсэн бөгөөд 1977 онд Гавар-25 найрлагыг эм болгон бүртгэсэн (Падма 28, Swissmedic No 35872). 2004/24/ЕС Европын шинэ удирдамж нь Австри (HERB-00037) болон Их Британид (39568/0001) дагаж мөрддөг уламжлалт ургамлын гаралтай эмийн бүтээгдэхүүн, бүртгэлийг нээх боломжийг нээж өгсөн”⁵ гэсэн бөгөөд энэхүү эм нь цусны эргэлтийг сайжруулах, цус дутагдсанаас зүрх өвдөх, гар хөл бадайрах, арьсны өнгөнд өөрчлөлт орох, доод мөчинд шархлаа үүсэх, үрэвсэл удаан хугацаанд үргэлжлэх, чих шуугих, толгой эргэх зэрэгт хэрэглэдэг⁶ олон улсад гарсан уламжлалт найрлага юм.

Монгол оточ Ламын Гэгээн Лувсанданзанжанцангийн 1639-1704 оны хооронд Төвөд хэлнээ туурвисан “Хамба номун ханы буман зарлигаас Хорин тавтын аймаг оршвой” зохиол нь өөрийн туршлагад тулгуурлан 25 найрлагатай 30 эм найрлагыг түүвэрлэн оруулсан. Энэхүү эмийн жорын түүвэртээ “Зарим эмийн хөлийг өөрийн орны нөхцөлд нийцүүлэн өөрчилсөн зүйл ажиглагдаж байгаа”⁴ бөгөөд олон улсад хүлээн зөвшөөрөгдөөд буй Гавар-25 найрлагыг тус

зохиолд ямар бүрэлдэхүүнтэйгээр, хэрхэн хувиргаж ирснийг судлан тогтоохоор энэхүү сэдвийг сонгон авлаа.

Зорилго: “Хамба номун ханы буман зарлигаас Хорин тавтын аймаг оршвой” бүтээлд буй Гавар-25 найрлагыг бусад сурвалж бичгээс тодруулан гаргаж, харьцуулан тайлбар хийх.

Зорилт:

Судалгааны хэрэглэгдэхүүн болгон авсан сурвалж бичгүүдээс Гавар 25 найрлагын тухай хэсгийг олох

Дээрх найрлагуудын эмийн түүхий эд, жорын бүрэлдэхүүн хэсгийг төрөлжүүлэн жагсааж ижил ба ялгаатай талыг харьцуулах

Эмийн жоруудыг харьцуулсан байдалд тайлбар хийх

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй:

1. Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн, эх сурвалж
2. Үндсэн хэрэглэгдэхүүнээр Ламын Гэгээн Лувсанданзанжанцангийн “Хамба номун ханы буман зарлигаас Хорин тавтын аймаг оршвой”^{ᠬᠠᠮᠪᠠ ᠨᠠᠮᠤᠨ ᠬᠠᠨᠤ ᠪᠤᠮᠠᠨ ᠵᠠᠷᠯᠢᠭᠠᠰ ᠬᠣᠷᠢᠨ ᠲᠠᠪᠲᠤᠨ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠣᠷᠰᠤᠪᠣᠢ} модон барын Төвөд судар.
3. Анагаах ухааны дөрвөн үндэс. (Төвөд, Монгол хэлээр) УБ, 2001 он
4. Ишбалжир (Сүмбэ хамба). Дөрвөн рашаан (Рашааны цагаан шүүдэр). Өвөр Монголын хэвлэлийн бүлэг. 2015
5. Миндол Жамбал Жамбалчойжиданзан-пэрэнлэй. Манаг ринчин жунай
6. Лувсанчойнпил. Нандин Эрдэнийн шимийн хураангуй

Судалгааны арга

2.1 Сурвалж бичгийн судлалын арга: Эх бичгийн судалгааг эх бичиг судлалын өнөөгийн түвшинд аль болох ойртуулж анагаах ухааны 5 судрын уг эх, нэр, гол онцлог, агуулга, эх хэрэглэгдэхүүн, тайлбар, харьцуулалт, хөрвүүлэг зэргийг нэг дор хамтатган судална.

2.2 Магадлан жагсаах арга: Магадлан жагсаах арга нь уламжлалт анагаах ухааны эмийн түүхий эд, жорын бүрэлдэхүүн хэсгийг төрөлжүүлэн жагсааж, тэдгээрийг тодорхойлсон

хэсгийг тодруулахад хэрэглэх арга юм.

2.3 Анализ, синтезийн арга: Энэ аргыг ашиглан судалж буй тухайн судар номыг бүхэлд нь задлан шинжлэв. Мөн задлан шинжилсэн материалдаа боловсруулалт, олон талын шинжилгээ, тайлбар, дүгнэлт хийж, синтезийн үр дүнд бий болсон шинэлэг тал, онцлог, ач холбогдлыг тайлбарлан тодорхойлов.

Үр дүн:

1. “Анагаах Ухааны Дөрвөн Үндэст” Дэлгэрсэн халууныг засах 16-р бүлэгт,

“Увдисын далай” номын дэлгэрсэн халууныг анагаах эм найрлагын бүлэгт, “Дөрвөн рашаан” номын халууныг анагаах бүлэгт, “Нандин эрдэнийн шимийн хураангуй” номын талхан эмийн найруулга бүлэгт, гавар-25 эм найрлагын талаар бичсэн байна.

2. Бид “Хамба номун ханы буман зарлигаас хорин тавтын найрлага оршвой” бүтээлд буй Гавар-25 найрлагыг дээрх сурвалж бичгүүдэд гарч буй Гавар-25-н найрлагатай харьцуулж үзэхэд дараах дүн гарав.




Figure 1. “Comparative data of Gavar-25 in the story ‘The Province of Twenty-Five’”

Дээрх зургаас үзвэл “Хорин тавтын аймаг оршвой зохиол” дээр тус тус зохиолуудаас давхацсан болон үл давхацсан эмийн түүхий

эдийн тоо ижил боловч нэр төрөл нь өөр байв. Үүнийг доорх хүснэгтээр үзүүлэв.

Table 1. Non-overlapping drug categories

No	Drug name, taste, quality of medicine, medicinal properties	Mkhan chen chos kyi rgyal po'i gsung 'bum las nyer lnga'i sde TSHAN	Four medical Tantras	Man ngag rin chen byung	The Four Medical Nectars	A Summary of the Precious Essence
1	Bezoar limonite ⁷ ᠪᠡᠵᠣᠷ ᠯᠢᠮᠣᠨᠢᠲᠤ	+	-	-	-	-
2	Odontites LUDW ⁹ ᠣᠳᠣᠨᠲᠢᠲᠤ	+	-	-	-	-
3	Cassia obtusifolia L. ⁷ ᠴᠠᠰᠢᠶ᠋ᠠ ᠣᠪᠲᠤᠰᠢᠳᠤᠯᠢᠰᠤ	+	-	-	-	-

4	Acacia catechu Willd. ⁷ ᠠᠨᠠᠭᠠᠭᠠᠬᠤ	+	-	-	-	-
5	Nigellia glandulifera ⁸ ᠨᠢᠭᠡᠯᠢᠭᠢ	+	-	-	-	-
6	Phytolacca acenosa L. ⁷ ᠰᠢᠨᠠᠭᠠᠭᠠᠬᠤ	+	-	-	-	-
7	Gossampianus malabarica <DC.> Merr. ᠭᠣᠰᠠᠮᠫᠢᠨᠠᠭᠤᠨ ¹¹	+	-	-	-	-
8	Glycyrrhiza uralensis Fisch. ⁷ ᠭᠢᠯᠢᠴᠢᠷᠷᠢᠵᠢ	+	-	-	-	+
9	Aquilaria agallocha Roxb. ⁷ ᠠᠬᠤᠯᠢᠭᠢᠷᠢᠭᠢ	-	+	+	+	+
10	Aquilegia sibirica ⁷ ᠠᠬᠤᠯᠢᠭᠢᠭᠢ	-	+	+	+	+
11	Medicago archiducisnicolai ⁸ ᠮᠡᠳᠢᠴᠢᠭᠠᠨ	-	+	+	+	+
12	Parmelia saxatilis Ach. ^{7,11} ᠫᠠᠷᠮᠡᠯᠢᠭᠢ	-	+	+	-	+
13	Curcuma longa ⁸ ᠴᠢᠷᠴᠤᠮᠤ	-	-	-	+	
14	Hippophae ramnoides L. ⁷ ᠬᠢᠫᠤᠫᠤ	-	-	-	+	-
15	Sinomlimprichtia algina ⁸ ᠰᠢᠨᠣᠮᠯᠢᠮᠫᠢᠷᠢᠲᠢᠭᠢ	-	-	-	+	-
16	Saussurealappa L. ⁷ ᠰᠠᠭᠤᠰᠤᠷᠡᠯᠠᠫᠫᠠ	-	+	+	+	+
17	Selaginella sanguinolenta L. ^{8,9} ᠰᠡᠯᠭᠢᠨᠡᠯᠡᠯᠠ	-	+	+	-	+
18	Cinnamomum cassia ⁸ ᠴᠢᠨᠨᠠᠮᠣᠮᠤᠮᠤ	-	+	+	+	-
19	Valeriana officinalis L. ¹⁰ ᠠᠶᠢᠯᠢᠷᠢᠨᠠ	-	+	+	-	+

Дээрх хүснэгтээс харахад “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс” зохиол болон Увдисын далай зохиол 2-ын гавар-25-ын найрлага ижил бөгөөд тус эрдэм нь ч ижил, харин Нандин Эрдэнийн шимийн хураангуй зохиолд дээрх 2 зохиолоос шинцагийн оронд чихэр өвсийг хувируулан хэрэглэсэн ч чадлын хувьд ялгаа байхгүй байна. Дөрвөн Рашаан зохиолд бусад зохиолд байхгүй 3 эмийн түүхий эд байгаа боловч эмийн чадал үйлдлийн хувьд дээрх 3 зохиолтой ойролцоо бичигдэн үлдсэн байна. Харин Ламын Гэгээн Лувсанданзанжанцангийн бүтээлд бусад 4 зохиолд байхгүй 7 эмийн түүхий эд байгаа бөгөөд чадлын хувьд ч ялгаатай байдал харагдав.

Тус эрдмийн хувьд гэвэл Лувсанданзанжанцаны жор: дэлгэрсэн халуун, халуун шар ус, гарагийн язгуур, ялангуяа гал саа нугуудад сайшаагдсан хэмээсэн байхад “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс” жорд: Тус

эрдэм нь цул сав, мах, арьс, судас ясны халуун хийгээд тархсан, хямарсан хижиг, хорын шинэ, хуучин халуун, тулай, хэрх, гал намс, дусал, идээ цувирах, биед оршсон халууныг хоцроолгүй арилгана. Ялангуяа хуучирсан халуун сарнисныг ёроолоос нь гаргана гэсэн байна¹². “Нандин Эрдэнийн шимийн хураангуй” жорд: цул, сав доргисон, хямарсан хижиг, хор, шинэ хуучин, халуун, тулай, хэрлэг, гал намс, хэнхдэг, цээжний яр идээлэх, ялангуяа, халуун хуучирч сарнисан өвчнийг ёроолоос нь гаргана¹³. Увдисын далай”-н жорд: Дэлгэрсэн халуунд хэрэглэнэ¹⁴. Дөрвөн Рашаан”-ы жорд: Дэлгэрсэн халууныг дарна, цус шарын хатгалгыг дарна¹⁵ гэснээс харахад Гавар-25-ийн ерөнхий чадал нь дэлгэрсэн халууныг арилгах, хэрэх тулай зэрэг шар усны өвчин, гал саа өвчин гэх мэт өргөн хүрээний үйлдэлтэй, олон өвчинд хувируулан хэрэглэдэг байсан нь харагдаж байна. Мөн Ламын Гэгээн

Лувсанданзанжанцангийн бүтээлд шар усыг хатаах, халууныг арилгах, хор тайлах хөлөг эмүүдийг хувируулан хэрэглэсэн нь тус найрлагын бусад зохиолд дахь найрлагын чадлаас ялгагдах ялгааг гаргаж өгөхийн зэрэгцээ тухайн үед Монголчуудын дунд шар ус түүнээс үүдэлтэй хуян шар ус, хэрэх өвчин элбэгтэй холбоотой хийсэн өөрчлөлт гэж үзэж болох юм.

Дүгнэлт

Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн туурвисан “Хорин тавтын аймаг оршвой” бүтээл дэхь Гавар-25 найрлага нь бусад зохиол дахь Гавар-25-ын найрлагаас 7 эмийн түүхий эдээр өөр бөгөөд чадал нь “Дэлгэрсэн халуун, халуун шар ус, саа өвчний зүйлийг арилгана” хэмээн шар усан өвчин болон саа өвчнийг засах чадал орсон байна.

Хэлцэмж:

Хамба Номун Хан Лувсанданзанжанцан таван ухаанд нэвтэрсэн эрдэмтнээр барахгүй Монгол анагаах ухааны эрдэм судлалын ажлыг өргөжүүлэн улмаар анагаах ухааныг сурч эзэмшсэн анхны Монгол эмч буюу Энэтхэг, Төвөдийн эрдэмтдийн шилдэг бүтээлүүдэд дүгнэлт, тайлбар хийсэн хүн гэж үздэг. Тиймээс Хамба номун хан Лувсанданзанжанцангийн анагаах ухааны бүтээлүүд өөрийн туршлагаас гадна Энэтхэг, Төвөдийн анагаах ухааны мэргэдийн олон арван ном судар, гарын авлагыг нарийвчлан судалж бичсэн хамгийн итгэмжтэй эмчилгээний аргуудыг багтаасан бүтээл болох нь тодорхой байна.¹⁶

Мөн “Хорин тавтын аймаг оршвой” бүтээлийг Сээсрэгдорж С. Жамьянгарав Д. Ламын гэгээн Лувсанданзанжанцаны “Увдисын рашааны цацрал” бүтээлийн шинжлэл хэмээх бүтээлдээ “Хорин тавтын аймаг оршвой” бүтээл дэх жорууд нь харьцуулж буй зохиолуудад ховор байгаа төдийгүй жорын бүрэлдэхүүн, өвчний үе шатанд тохируулан найруулах арга, нэмэр эм тавих тухай болон туршлагаар нотолгоожин сонгогдож бичигдсэнээрээ онцлог ялгаатай байна. Зохиолуудын орчуулгаас авч үзвэл бүтээлийн агуулга товч, оновчтой бусдаас ялгарах өөрийн онцлогтой, эмнэл зүйн ач

холбогдол ихтэй, зарим эмийн түүхий эдүүдийг нууц нэрээр нэрлэсэн байгаа нь анагаах ухаан бол хүн бүхний таалах орон биш гэдгийг батлахын зэрэгцээ муу санаатнаас далдлах хийгээд эх байгалиа хамгаалах давхар санаа агуулагдаж бичигдсэн байна” гэжээ. Мөн гавар-25 жорыг « Анагаах Ухааны Дөрвөн Үндэс», “Манагживаринсэрэл”, “Увдисын рашааны цацрал” гэсэн зохиолуудаас түүвэрлэн авч хооронд харьцуулсан дүн шинжилгээ хийхдээ “Харьцуулж буй бүтээлүүдэд Гавар-25-н найрлага “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс”-ийн бүсүханаас бусад эмийн түүхий эд болон тус эрдэм нь адилхан ба харин энэ бүтээлүүдэд халууны хувь их бол “гурван үрийг хийх, хүйтний хувь их бол гаа, повари, библинг хийхээр заасан байна. Лувсанданзанжанцангийн бүтээлд “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс”-с 7 төрлийн эмийн түүхий эдийн зөрөөтэй ба бусад бүтээлүүдээс таван төрлийн түүхий эдийн зөрөөтэй байна. Энэ эмийн тус эрдэм нь дэлгэрсэн халуун болон халуун шар ус, гаргийн язгуур, ялангуяа гал саа нугуудад сайшаагдсаныг үзсэн гэснээс анхаарч үзвэл мөн л нотолгоожсон жор болох ба тус эрдэмд дурдсан “Энэ эмийг өгч үзсэн” гэдэг үг ч үүнийг баталдаг”¹ гэжээ.

Ном зүй

1. Сээсрэгдорж С., Жамьянгарав Д. Ламын Гэгээн Лувсанданзанжанцаны “Увдисын рашааны цацрал” бүтээлийн шинжлэл УБ, 2021, 51, 122.
2. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. УБ, Адмон ХҮ, 2006, 16.
3. Сүрэнжав Ч. “Монгол судлалын нэвтэрхий толь” Өвөр Монголын орны хэвлэлийн хороо, 2001, 87.
4. Болд Ш., Цэрэнсодном Ц. “Монголын уламжлалт анагаах ухааны эм найрлагын судлал” УБ, 2014, 56, 24.
5. Herbert Schwabl., Cécile Vennos; “From medical tradition to traditional medicine: A Tibetan formula in the European framework” journal-of-ethnopharmacology, 2015.
6. PADMA 28 N Цусан хангамж дутагдахад. <https://padma.mn/products/padma-28/>
7. Болд Ш., Цэрэнсодном Ц. “Монголын уламжлалт анагаах ухааны эм судлал” Улаанбаатар, 2014; 132, 148, 152, 154, 162, 163, 182, 192, 197.
8. Олдох С., Цэрэнцоо Б., Батхуяг П. “Монгол эмийн судлал” Улаанбаатар, 2013, 128, 327, 330, 333, 339.
9. Лигaa У. “Монгол орны эмийн ургамлыг өрнө дорнын анагаах ухаанд хэрэглэхүй” Улаанбаатар, 2015, 91, 239.
10. Цэцэгдарь Т. “Эмийн нэрсийн далай”-н сурвалж бичгийн судалгаа. Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Өвөр Монголын Үндэсний Их Сургууль, Тунлиао хот, 2023 он.
11. Лувсан. Монгол эмийн ойллого “Монгол эмийн ухаантан эрдэм шинжилгээний бүтээл” Өвөр Монголын Шинжлэх Ухаан Техникийн Мэргэжлийн Хэвлэлийн хороо, 265.
12. Анагаах ухааны дөрвөн үндэс. (Төвөд-Монгол бичгээр) Улаанбаатар, 2001, 80, 81.
13. Лувсанчойнпил. Нандин Эрдэнийн шимийн хураангуй Пүрэвсүрэн Б. Мэндсайхан З. нар орчуулав. Улаанбаатар. 1993, 11.
14. Миндол Жамбал Жамбалчойжиданзанпэрэнлэй. Манаг ринчин жунай
15. Ишбалжир (Сүмбэ хамба). Дөрвөн рашаан (Рашааны цагаан шүүдэр). Өвөр Монголын хэвлэлийн бүлэг. 2015, 137
16. Сумьяацэрэн Б. “Хамба номун хааны Увдист рашааны дусал сударт буй илт өгүүлэх нэр, зарим эмийн тайлбар” Анагаах ухааны магистрын зэрэг горилсон бүтээл. Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль 2022 он.